

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ НАЙМДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны гуравдугаар сарын 05-ны 14 цаг 13 минутад эхэлж, 15 цаг 35 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 22 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Барилга, хот байгуулалтын яамны зарим газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none">- Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулах- Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилуулах- Барилга, нийтийн аж ахуйн бодлогын газрын даргын албан тушаалд томилуулах- Барилгын чанар, аюулгүй ажиллагааны бодлогын газрын даргын албан тушаалд томилуулах- Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын даргын албан тушаалд томилуулах	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Ухнаагийн Отгонбаярыг Барилга, хот байгуулалтын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гарган, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Р.Эрдэнэбүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p>

Батсүхийн Баярсайханыг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гарган, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Р.Эрдэнэбүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:

Цэрэндондовын Ганбатыг Барилга, хот байгуулалтын яамны Барилгын чанар, аюулгүй ажиллагааны газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гарган, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Р.Эрдэнэбүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:

Бат-Өлзийгийн Баасанг Барилга, хот байгуулалтын яамны Барилга, нийтийн аж ахуйн бодлогын газрын

		<p>даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гарган, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Р.Эрдэнэбүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Барилга хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж дүгнэлт гаргуулах тухай асуудлыг хэлэлцээд, Төрийн албаны зөвлөлд дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн дөрвөн газрын даргын ажлын байранд тавигдсан туршлагын шаардлагатай адил тэгш байх нь зүйтэй гэж үзсэн Комиссын дүгнэлтийг дэмжээд, уг удирдах ажилтны ажлын байрыг нээлттэй сонгон шалгаруулалтаар нөхөх тухай албан тоотыг тус яаманд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.</p>
2	<p>Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн орлого, шимтгэлийн байцаагч Д.Энхтөгсөөс гаргасан гомдлын талаарх Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай</p>	<p>Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн орлого шимтгэлийн байцаагч Д.Энхтөгсөөс “Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай” Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 05 дугаар тогтоолыг эс зөвшөөрч Төрийн албаны зөвлөлд гаргасан өргөдөл үндэслэлтэй эсэхийг хянан шалгасан Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1, 39.5, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын “Нэг” дэх хэсгийн 3.6-д заасныг удирдлага болгон:</p>

		<p>1. “Д.Энхтөгст сахилгын шийтгэл ногдуулах тухай” Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн Б/80 дугаар тушаалыг хууль зүйн үндэслэлгүй гэсэн Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийг зүйтэй гэж үзэх.</p> <p>2. “Д.Энхтөгст сахилгын шийтгэл ногдуулах тухай” Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн Б/80 дугаар тушаалыг хүчингүйд тооцох.</p> <p>3. “Д.Энхтөгст сахилгын шийтгэл ногдуулах тухай” Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн Б/80 дугаар тушаалыг дахин хянаж үзэхийг даалгасан “Маргаан хянан шалгах комиссын дүгнэлтийн тухай” Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2015-ны 02 дугаар сарын 13-ны өдрийн 05 дугаар тогтоолыг хүчингүйд тооцох. Төрийн албаны зөвлөлийн хуралдаанаас гарсан тогтоолыг Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6-д заасны дагуу биелүүлж ажиллахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Салбар зөвлөлд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөхөөр 2009 онд, Говь-Алтай аймгийн Засаг даргаар 2010-2014 онд ажиллаж байсан Ш.Амгаланбаярыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17.11, Улсын Их Хурлын 2002 оны 73 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөхийн албан тушаалд 2009 оны 01 дүгээр сарын 09-ны өдрөөс 2009 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн хооронд, Говь-Алтай аймгийн Засаг даргын албан тушаалд 2010 оны 9 дүгээр сарын 17-ны өдрөөс 2014 оны 02 дугаар 10-ны өдрийн</p>

		<p>хооронд томилогдон ажиллаж байсан Шархүүгийн Амгаланбаярыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Ховд аймгийн Боловсролын газраас зохион байгуулсан Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын тухай</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн ээлжит хуралдаанаар Ховд аймгийн Боловсролын газраас 2015 оны хоёрдугаар сарын 25-нд зохион байгуулсан Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны нээлттэй сонгон шалгаруулалтын тайлан, дүнг хянан шалгасан Мэдээлэл хянан шалгах комиссын дүгнэлтийг хэлэлцээд:</p> <p>Ховд аймгийн Боловсролын газраас ирүүлсэн “Сонгон шалгаруулалтын тухай” 2015 оны хоёрдугаар сарын 27-ны өдрийн 58 тоот албан бичигт "сонгон шалгаруулалтыг ХоИС-ийн байр, танхим, компьютер техник хэрэгсэл, сүлжээг ашиглах түрээсийн төлбөр төлөх боломжгүй байдлаас шалтгаалан цахим хэлбэрээр зохион байгуулаагүй" гэсэн нь Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан "шударга ёс, тэгш байдал"-ын зарчмыг, мөн зүйлийн 4.2.2, 4.2.4-т заасан зарчмуудыг, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны дөрөвдүгээр сарын 11-ний өдрийн 60 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын үнэлгээ, дүгнэлт гаргах заавар”-ын 3.1.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна гэж дүгнээд, 2015 оны хоёрдугаар сарын 25-нд зохион байгуулсан сонгон шалгаруулалтыг хүчингүй болгож, сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр, шинээр 2015 оны гуравдугаар сарын 20-ны дотор зохион байгуулахыг Төрийн албаны зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээр үүрэг болгох нь зүйтэй гэж</p>

		үзэв.
5	Төрийн албаны зөвлөлийн Уул уурхайн яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргыг өөрчлөн томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 3.3, Уул уурхайн сайдын 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 1/477 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Уул уурхайн яамны дэргэдэх салбар зөвлөлийн даргаар тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Даваасүрэнгийн Артагийг 2015 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн томилох.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 131 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын нэгийн 9-д "Рэнцэндоогийн Жигжид" гэснийг "Даваасүрэнгийн Артаг" гэж өөрчлөх.</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга Д.Артагт үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
6	Зарим албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйл, "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмыг батлах тухай" Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор баталсан журмын 2, 6 дахь заалт, "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журамд өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын 2000 оны 20 дугаар тогтоолын 1-д заасны дагуу төрийн захиргааны албан тушаалын тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулахаар ирүүлсэн саналыг хэлэлцээд, арван</p>

		албан хаагчдад эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулах саналыг Засгийн газарт уламжлахаар шийдвэрлэв.
7	Бусад асуудал /Ховд аймагт зохион байгуулах сонгон шалгаруулалт хойшлуулах тухай/	Ховд аймагт малын гоц халдварт өвчин шүлхий гарч аймгийн Засаг даргын 2015 оны гуравдугаар сарын 02-ны А/64 тоот захирамжаар "Шүлхий өвчний хөл хорионы хатуу дэглэм" тогтоосон тул 2015 оны гуравдугаар сарын 12-ны өдөр авахаар товлон зарласан төрийн жинхэнэ болон үйлчилгээний албаны удирдах ажилтны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг хөл хорио цуцлагдтал тодорхойгүй хугацаагаар хойшлуулахаар шийдвэрлэв.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ